АЖЛЫН ДААЛГАВАР

Тендер шалгаруулалтын нэр, дугаар : “Аймгуудын Байгаль орчин, аялал жуулчлалын газруудыг үндсэн тоног төхөөрөмжөөр хангах” БОЯБХУАӨДЗТөсөл/20240902004

№	Ажлын нэр, төрөл	Тайлбар
1.	Төслийн зорилго	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Монгол Улсын Засгийн газар хоорондын хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд Германы Сэргээн босголт, Зээлийн банк *(KfW)*-аар дамжуулан БОАЖЯ-ны хэрэгжүүлж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн 2, 3-р үе шатны үйл ажиллагаа 2020 оны 3 дугаар сараас эхлэн хэрэгжиж байна. Төслийн зорилго: Монгол орны ТХГН-ийн сүлжээнд (Орчны бүс нутаг болон Орон нутгийн захиргаад, иргэд) чухал ач холбогдол бүхий газруудын үр ашигт байдал, тогтвортой менежментийг сайжруулах, нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааны шинэ эх үүсвэрүүдийг бий болгоход дэмжлэг үзүүлэх юм. Төсөл нь 4 үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэйгээр хэрэгжинэ. Үүнд: Бүрэлдэхүүн хэсэг 1: ТХГН-ийн болон (орчны бүс, эко-холбоос нутгуудыг хамруулан) менежментийн ба бизнесийн төлөвлөлтийг Олон улсын байгаль хамгаалах холбооны (ОУБХХ-IUCN) удирдамж, стандартын дагуу боловсруулах, шинэчлэн сайжруулах, ТХГН-ийн сүлжээний хэмжээнд менежментэд шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах; Бүрэлдэхүүн хэсэг 2: Газарзүйн томоохон бүс нутаг буюу төсөлд хамрагдсан ТХГН-ийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, шаардлагатай хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх; Бүрэлдэхүүн хэсэг 3: Тогтоосон шалгуурын дагуу сонгосон бие даасан 7 ТХГН-ийн менежментийн болон бизнес төлөвлөгөөг нь сайжруулж, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх; Бүрэлдэхүүн хэсэг 4: ТХГН-ийн сүлжээний хэмжээнд чадавхыг дээшлүүлэх, олон нийтэд таниулан сурталчлах арга хэмжээнүүдийг зохион байгуулах; “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл”-ийн 2 болон 3 дугаар үе шат нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн болон орчны бүсийн менежментийн

		төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар тусгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бүс нутгийн тогтвортой байдлыг хангах зорилготой.
2.	Ажлын үндэслэл, зорилго	Төслийн зорилтот байгууллага болох тусгай хамгаалалттай газар нутгаар хязгаарлагдалгүй, байгалийн нөөц баялаг, биологийн олон янз байдал, экосистемийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бусад байгаль орчны байгууллагуудыг дэмжсэнээр талуудын хамтын ажиллагааг хангах, биологийн олон янз байдлыг хамгаалах зэрэг төслийн үндсэн зорилгод нийцэж эерэг нөлөө үзүүлнэ. Аймгуудын байгаль орчин, аялал жуулчлалын газрын алба хаагчид ажил үүргийн онцлогоос хамааран хээр, хөдөө буюу төв сууринаас хол, алслагдмал зайд, асар өргөн уудам газар нутагт ажиллах, судалгаа шинжилгээ, ажиглалт, хяналт мониторинг хийх шаардлагатай байдаг. Эдийн засгийн хүндрэлтэй байдал болон төсөв санхүүжилт хангалтгүй учир ихэнх байгаль орчны байгууллагуудад 2012-2014 оноос хойш хээрийн ажлын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдээгүй, байгаа тоног төхөөрөмж нь олон жил удаан хэрэглэгдсэний улмаас элэгдэж, хуучирч ажлын шаардлага хангахгүй болсон байна. Төслийн 1-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд аймгуудын Байгаль орчин, аялал жуулчлалын газруудын ажилтнууд хээрийн нөхцөлд ажиллах, судалгаа шинжилгээ, хяналт, мониторинг хийхэд нэн шаардлагатай байгаа үндсэн хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийг нийлүүлэх ажлыг 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан нь энэхүү худалдан авалтын ажлын үндэслэл болно. Байгаль орчин, аялал жуулчлалын газруудыг орчин үеийн дэвшилтэт технологийн давуу талыг ашигласан, хээрийн нөхцөлд хэрэглэхэд хялбар, Олон улсын стандарт шаардлагад нийцсэн үндсэн хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангахад энэхүү тендерийн зорилго оршино.
3.	Хамрах хүрээ	Тус тендерийн хүрээнд 16 аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт дэмжлэг үзүүлнэ. Барааны хуваарилалтыг одоо ажиллаж буй орон тоонд үндэслэн тооцоолсон бөгөөд Ажлын даалгаврын хоёрдугаар хавсралтаас харна уу.

4.	Хүлээн авах бараа, тоо ширхэг	Тус тендерийн хүрээнд нийт 9 нэр төрлийн 2741 ширхэг барааг Захиалагчид хүлээлгэн өгнө. Үүнд: 1) Гар чийдэн – 334 ширхэг; 2) Аяны хөнжил – 522 ширхэг; 3) Аяны гудас – 522 ширхэг; 4) Аяны үүргэвч – 313 ширхэг; 5) Аяны майхан (2 хүний) - 313 ширхэг; 6) Аяны майхан (4 хүний) – 32 ширхэг; 7) Анхны тусламжийн хайрцаг – 37 ширхэг; 8) Зөөврийн цэнэглэгч (Power bank) – 334 ширхэг; 9) Усны халуун сав - 334 ширхэг; Захиалагчийн техникийн тодорхойлолтыг Ажлын даалгаврын нэгдүгээр хавсралтаас харна уу.
5.	Хийх ажлын иж бүрдэл	➢ Гэрээнд заасан тоо, чанар, техникийн үзүүлэлт бүхий үндсэн тоног төхөөрөмжийг гэрээний хугацаанд нийлүүлж 16 аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүлээлгэн өгнө. ➢ Хүлээлгэн өгөх үедээ бараа бүтээгдэхүүний ашиглалттай холбоотой мэдээлэл агуулсан мэдээ материалыг монгол хэл дээр бэлтгэж бараа бүтээгдэхүүний хамт хүлээлгэн өгнө.
6.	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээнд гарын үсэг зурснаас хойш 150* хоногийн хугацаанд хийж гүйцэтгэнэ. *Гэрээний нийт үргэлжлэх 150 хоногийн хугацаа нь Гэрээлэгч барааг Захиалагчид хүлээлгэн өгч, акт үйлдэж, Захиалагч гэрээний эцсийн төлбөрийг Гэрээлэгчийн дансанд шилжүүлсэн байхаар тооцсон хугацаа болно.
7.	Хүрэх үр дүн	✓ Төсөлд хамрагдсан аймгуудын Байгаль орчин, аялал жуулчлалын газруудын мэргэжилтэн, албан хаагч, ажилтан, байгаль хамгаалагчдын хээрийн нөхцөлд ажиллах орчин, нөхцөл сайжирна. ✓ Байгаль орчин, биологийн олон янз байдал, экосистемийг хамгаалах ажилд ахиц гарч, байгалийн нөөцийн тогтвортой менежментийг хөгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ. ✓ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилт сайжирна.

8.	Тендерт оролцогчид тавигдах шаардлага	▪ Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1-д заасныг үндэслэн захиалагчийн тогтоосон чадавхын шаардлагыг хангасан байх; ▪ Техникийн тодорхойлолт; ▪ Тендерийн баримт бичигт заасан Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн Босголт, Зээлийн банк (*KfW*)-ны бусад нөхцөл, шаардлага;
9.	Захиалагч байгууллага	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
10.	Санхүүжилтийн эх үүсвэр	Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд Германы Сэргээн босголт, Зээлийн банк (*KfW*)-аар дамжуулан Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хэрэгжүүлж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III” BMZ 201667054, 201868272 төсөл
11.	Нийт санхүүжилт	Тендерийн төсөвт өртөг: 803,657,800.00 төгрөг (найман зуун гурван сая зургаан зуун тавин долоон мянга найман зуун төгрөг)
12.	Худалдан авах ажиллагаанд дагаж мөрдөх хууль, дүрэм журам	❖ Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголт, зээлийн банк (*KfW*)-ны “Түншлэгч улсуудтай хийх санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд зөвлөх үйлчилгээ, ажил, үйлдвэрийн байгууламж, барааны болон зөвлөх бус үйлчилгээ худалдан авах ажиллагааны удирдамж”; ❖ Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн Босголт, Зээлийн банк (*KfW*)-ны БОНМБ-ын шаардлага, стандартууд; ❖ Санхүүжүүлэгчээр батлагдсан Бараа нийлүүлэх тендерийн баримт бичиг; ❖ Захиалагчаар батлагдсан Тендерийн баримт бичиг болон Ажлын даалгавар;

“Аймгуудын Байгаль орчин, аялал жуулчлалын газруудыг үндсэн тоног төхөөрөмжөөр хангах” БОЯБХУАӨДЗТөсөл/20240902004 тендер шалгаруулалтын Ажлын даалгаврын Нэгдүгээр хавсралтаар тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг, Хоёрдугаар хавсралтаар барааны хуваарилалтыг батлав.

---------- 0 ---------- 0 ---------- 0 ----------

АЖЛЫН ДААЛГАВРЫН НЭГДҮГЭЭР ХАВСРАЛТ

“Аймгуудын Байгаль орчин, аялал жуулчлалын газруудыг үндсэн тоног төхөөрөмжөөр хангах” тендерээр нийлүүлэх барааны техникийн тодорхойлолт

№	Барааны нэр	Техникийн үзүүлэлт	Тоо ширхэг
1.	Гар чийдэн	*Хамгийн багадаа доорх үзүүлэлтийг хангасан байна.* - 3.5 *AH*, 6*W*-аас доошгүй хүчин чадалтай, өндөр энергийн нягтралтай байх; - 1000 удаа хүртэлх дахин цэнэглэх батарейтай, ус үл нэвтрэх, доргилтод тэсвэртэй байх; - Хол, ойрын гэрлийн тусгалын тохиргоотой. - Гар чийдэнг дагалдаж USB гаралттай залгуур ирэх ба үүнийг ашиглан зөөврийн цэнэглэгч, гар утас цэнэглэх боломжтой байх; - *ISO* 9001:2015 хүчин төгөлдөр чанарын стандартын гэрчилгээтэй байх; - Баталгаат хугацаа: 12 сараас доошгүй байх;	334
2.	Аяны хөнжил	*Хамгийн багадаа доорх үзүүлэлтийг хангасан байна.* - Жин: 4,5 кг-аас ихгүй байх; - Хамгийн багадаа -18-20^{0}С-д хэрэглэх боломжтой байх; - Зузаан 3,5 см багагүй байх; - Материал: Сайн чанарын синтетик байх, угааж цэвэрлэх боломжтой байх; - Дотор дүүргэлтийн материал: Өд, сөдөн биш; - Гадуураа уут савтай байх; - Хэмжээ: 1 хүний зориулалттай, 200*90см-аас багагүй хэмжээтэй байх (Mummy загвар биш); - *ISO* 9001:2015 хүчин төгөлдөр чанарын стандартын гэрчилгээтэй байх; - Баталгаат хугацаа: 12 сараас доошгүй байх;	522
3.	Аяны гудас	*Хамгийн багадаа доорх үзүүлэлтийг хангасан байна.* - Материал: Ус, чийг нэвтэрдэггүй бүрээстэй байх; - Гадуураа уут савтай байх; - Хийлдэггүй, автоматаар агаар сордог, эвхэгддэг байх; - Хэмжээ: 1 хүн; 200х90см багагүй байх; - Гудасны зузаан хийлсэн үед багадаа 7см байх - *ISO* 9001:2015 хүчин төгөлдөр чанарын стандартын гэрчилгээтэй байх; - Баталгаат хугацаа: 12 сараас доошгүй байх;	522
4.	Аяны үүргэвч	*Хамгийн багадаа доорх үзүүлэлтийг хангасан байна.* - Шаардлага: Загвар хийц сайтай, чанартай, ус чийгийн хамгаалалттай, эдэлгээ даахуйц материалтай байх; - Өнгө: аль болох байгалийн өнгөтэй ууссан байх; - Аяны хөнжил, гудас болон солих хувцас, бусад хэрэгсэл авч явах 40л-ээс багагүй багтаамжтай, жижиг зүйлс хийх хэд хэдэн халаас тасалгаатай байх;	313

		- *ISO* 9001:2015 хүчин төгөлдөр чанарын стандартын гэрчилгээтэй байх; - Баталгаат хугацаа: 12 сараас доошгүй байх;	
5.	Аяны майхан (2 хүний)	*Хамгийн багадаа доорх үзүүлэлтийг хангасан байна.* - Загвар хийц сайтай, чанартай, эдэлгээ даахуйц байх; - Гадна, дотор давхарга: давхаргууд нь тус тусдаа салангид байх ба ус, салхи нэвтэрдэггүй материалаар хийгдсэн байх; - Багана нуруу нь хөнгөн цагаан эсвэл файбаргласаар хийгдсэн бөгөөд үүдний хэсэг нь тусгаарлах хаалгатай байх; - Бороо, салхины болон нарны хэт ягаан туяаны хамгаалалттай, бат бөх цахилгаантай, шавж, ялаа шумуулаас маш сайн хамгаалагдсан байх - Шал: майхны шалны хэсэг усны хамгаалалт бүхий материалаар хийгдсэн байх; - Усны хамгаалалт: 3000мм - Салхинд тогтвортой, эвхэж хураахад амархан байх; - Өндөр: Багадаа 44’’/112 см/ байх; - Цэвэр талбай нь багадаа: 2,9m2 бүхий 2 хүний зориулалттай байх; - Гадуураа бат бөх уут савтай байх; - *ISO* 9001:2015 хүчин төгөлдөр чанарын стандартын гэрчилгээтэй байх; - Баталгаат хугацаа: 12 сараас доошгүй байх;	313
6.	Аяны майхан (4 хүний)	*Хамгийн багадаа доорх үзүүлэлтийг хангасан байна.* - Загвар хийц сайтай, чанартай, эдэлгээ даахуйц байх; - Гадна, дотор давхарга нь тус тусдаа байх ба ус, салхи нэвтэрдэггүй материалаар хийгдсэн байх; - Багана нуруу нь хөнгөн цагаан эсвэл файбарглассаар хийгдсэн бөгөөд үүдний хэсэг нь тусгаарлах том хаалгатай байх; - Бороо, салхи, нарны хэт ягаан туяаны хамгаалалттай, бат бөх цахилгаантай, шавж, ялаа шумуулаас маш сайн хамгаалагдсан ба усны хамгаалалт бүхий шалтай байх; - Салхинд тогтвортой, эвхэж хураахад амархан байх ба майхны гадна болон дотор давхаргатай байх; - Өндөр: Багадаа: 59’’/150 см/ байх; - Цэвэр талбай нь багадаа: 5,8m2 бүхий 4 хүний зориулалттай байх; - Гадуураа бат бөх уут савтай байх; - *ISO* 9001:2015 хүчин төгөлдөр чанарын стандартын гэрчилгээтэй байх; - Баталгаат хугацаа: 12 сараас доошгүй байх;	32
7.	Анхны тусламжийн хайрцаг	*Хамгийн багадаа доорх үзүүлэлтийг хангасан байна.* **Зориулалт: Хөнгөн гэмтэл авсан хүнд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх иж бүрдлийн бүрэлдэхүүн** - Хөвөн: Эмнэлгийн боодлоор 5 ш-ээс багагүй байх;	37

		- Ариутгасан боох материал /бинт/: 15 ш-ээс багагүй байх; - Уян боолт: 2 төрлөөс 2 ширхэг - Ариутгасан наалтад боох материал: 15 ш-ээс багагүй - Ариутгасан хөвөн: эмнэлгийн боолтоор 15 ш-ээс багагүй байх; - Цус тогтоогч уяа: 2 ш-ээс багагүй байх; - Шархны лент/боолт/: 15 ш-ээс цөөнгүй байх; - Тарианы салфетка: Боодлоор 30 ш-ээс багагүй - Иодын уусмал: 10 граммаар 2 ш, - Ариутгалын спирт: 50 мл-с багагүй байх; - Пинцепт: 2 ш, - Хайч, - Цайртай тос - Марганц: 2 боодол байх; - Ойрын хэрэглээний гол нэрийн эм (Антибиотик, өвчин намдаагч, үрэвсэл, түлэнхийн)-үүдтэй байх; - Тариурын бээлий: 1 хайрцаг - Химидин - 0,5%, Тамедин уусмал- 0,75 %, - Панкипсин тос, Аннистезин тос байх; - Цүнхний хэмжээ мм: 250х230х120мм; - Цүнхний жин: Ойролцоогоор 0,5кг байх ба ус чийг нэвтрэхгүй, бат бөх материалаар хийгдсэн байх; - Тусламжийн хайрцагт заавал байх эм, эд зүйлсийн жагсаалт хэрэглэх зааврын хамт (норох болон алга болохоос хамгаалагдсан байх) - Баталгаат хугацаа: 12 сараас доошгүй байх;	
8.	Зай хураагуур (*Power bank*)	*Хамгийн багадаа доорх үзүүлэлтийг хангасан байна.* - Хамгийн багадаа 20000 mAh байх; - 3.0А хурдан цэнэглэдэг байх; - Олон төрлийн оролт/Type C, USB/, гаралт /Type C, micro USB, iPhone/-тай байх; - Доргилтод тэсвэртэй, хамгаалагдсан байх; - Вольт хэтрэх болон илүү цэнэглэхээс хамгаалсан хамгаалалттай байх. - *ISO* 9001:2015 хүчин төгөлдөр чанарын стандартын гэрчилгээтэй байх; - Баталгаат хугацаа: 12 сараас доошгүй байх;	334
9.	Усны халуун сав	*Хамгийн багадаа доорх үзүүлэлтийг хангасан байна.* - Гадна болон дотор тал нь зэвэрдэггүй ган материалаар хийгдсэн байх; - Хамгийн багадаа 1 л-ийн багтаамжтай байх; - Хамгийн багадаа 12 цаг халуун, хүйтнээ барьдаг байх; - Овор хэмжээ багатай, авч явахад хөнгөн байх; - Доргилтод тэсвэртэй, хамгаалагдсан байх; - *ISO* 9001:2015 хүчин төгөлдөр чанарын стандартын гэрчилгээтэй байх; - Баталгаат хугацаа: 12 сараас доошгүй байх;	334
Нийт тоо ширхэг			**2741**

---------- 0 ---------- 0 ---------- 0 ----------

АЖЛЫН ДААЛГАВРЫН ХОЁРДУГААР ХАВСРАЛТ

“Аймгуудын Байгаль орчин, аялал жуулчлалын газруудыг үндсэн тоног төхөөрөмжөөр хангах” (БОЯБХУАӨДЗТөсөл/20240902004) худалдан авалтаар нийлүүлэх тоног төхөөрөмжийн хуваарилалт

№	Аймаг	гар чийдэн	Зай хураагуур	халуун сав	2 хүний аяны майхан	үүргэвч	4 хүний майхан	анхны тусламжийн хайрцаг	аяны гудас	аяны хөнжил
1	Дархан	4	4	4	3	3	2	2	13	13
2	Өвөрхангай	16	16	16	15	15	2	2	27	27
3	Орхон	3	3	3	2	2	2	2	13	13
4	Завхан	42	42	42	40	40	2	3	56	56
5	Сэлэнгэ	34	34	34	32	32	2	3	46	46
6	Дундговь	9	9	9	8	8	2	2	20	20
7	Булган	28	28	28	26	26	2	3	40	40
8	Дорноговь	2	2	2	1	1	2	2	13	13
9	Говь-Сүмбэр	3	3	3	2	2	2	2	10	10
10	Хөвсгөл	54	54	54	52	52	2	3	70	70
11	Төв	36	36	36	35	35	2	2	49	49
12	Дорнод	20	20	20	19	19	2	2	35	35
13	Архангай	37	37	37	36	36	2	2	49	49
14	Өмнөговь	14	14	14	13	13	2	2	27	27
15	Сүхбаатар	11	11	11	10	10	2	2	20	20
16	Хэнтий	21	21	21	19	19	2	3	34	34
Нийт тоо ширхэг		**334**	**334**	**334**	**313**	**313**	**32**	**37**	**522**	**522**
Зориулалт		БХ + машин			БХ		Оф-фис	Машин	БХ+удирдлага+мэргэжилтэн+байцаагч+жолооч	

---------- 0 ---------- 0 ---------- 0 ----------